



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/57

Амардалай

Хоршоо хөгжүүлэх сангаас
зээл олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 22.1.5, 59 дүгээр зүйлийн 59.1.7, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/243 дугаар тушаалын хавсралт 3 дугаар зүйлийн 3.2.5, 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 8 дугаар зүйлийн 8.3 тушаал, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 31 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хоршоо хөгжүүлэх"-ийн Төсөл сонгон шалгаруулах хорооны хуралдаанаар дэмжигдсэн орон нутгийн нөөцөд түшиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх 6 иргэний зээлд шаардагдах 141,200,000 (зуун дөчин нэгэн сая хоёр зуун мянган) төгрөгийн төслийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Хөнгөлөлттэй зээлийг зориулалтын дагуу ашиглан баталсан хуваарийн дагуу төлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл үйлчилгээний тайланг улирал бүр тайлагнаж, ажлын байрыг шинээр нэмэгдүүлж, тогтвортой хадгалж, эрүүл аюулгүй үйлдвэрлэл, үйлчилгээгээр хангаж ажиллахыг нийт зээлдэгч иргэдэд үүрэг болгосугай.

3.Зээл олгогдсон иргэн, хуулийн этгээдүүдэд зээлийн зориулалт ажлын байр, үйл ажиллагаа, эргэн төлөлтөд хяналт тавьж тайлагнаж ажиллахыг "Хоршоо хөгжүүлэх сан"-ийн хариуцсан мэргэжилтэн (Д.Наранцэцэг) нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн) нарт даалгасугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

Сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 18-ны
өдрийн А/57 тоот захирамжийн хавсралт

№	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, багийн харьяалал	Төслийн чиглэл	Төсөлд олгосон санхүүжилт
1	"Уран шаглаа оёдол"	А.Нямцэрэн 2-р баг	Оёдол эсгүүр	30.000.000
2	"Сүүн хишиг"	Д.Мөнхжаргал 3-р баг	Сүү, сүүн бүтээгдэхүүн	26.200.000
3	"Махны үйлдвэрлэл болон толгой шийр дайвар бүтээгдэхүүнээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл"	З.Түвшинтөр 2-р баг	Махны худалдаа, толгой шийр дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэх	40.000.000
4	"Ган хийц"	А.Адъяа 2-р баг	Гагнуур төмөр хийц	15.000.000
5	"Амар сольюшн"	В.Амаржаргал 1-р баг	Авто засвар, гагнуур төмөр үйлдвэрлэл	20.000.000
6	"Сүүн цагаан идээ боловсруулах"	П.Амгаланбаатар 3-р баг	Цагаан идээний үйлдвэрлэл	10.000.000
			Дүн	141.200.000